

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/2019 оны 3 дугаар улирал/

2019 оны 10 дугаар сарын 04

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/266 дугаар захирамжаар батлагдсан “Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар;
2. “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70371212 дугаарын нээлттэй утсаар;
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”, төвийн 70371313 дугаарын утсаар;
4. www.darkhan.gov.mn, [Smartdarkhan](#) цахим хуудсаар;
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр;
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 9807 өргөдөл, гомдол ирүүлснээс 9401 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 406 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 96 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 9322 хүсэлт, 104 санал, 381 гомдол тус тус эзэлж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 552 өргөдөл, гомдол ирүүлснээс 513 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 39 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93 хувьтай байна. Өргөдөл, гомдлын мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн үйл ажиллагаанд тусгаж, өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ /2019 оны 3 дугаар улирал/**

2019 оны 10 дугаар сарын 04

Дархан-Уул аймаг
Хүснэгт 1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Шийдвэрлэлт		Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /%/
				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	АЗДТГ-ын дүн	552	513	0	0	39	93.00%
2	Сумдын дүн	3590	3486	1491	0	104	97.00%
3	Агентлагийн дүн	5665	5402	99	0	263	95.00%
ДҮН		9807	9401	1590	0	406	96.00%

Өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр нь/

Хүснэгт 2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс					Бусад
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	
1	АЗДТГ-ын дүн	552	255	28	0	269	0	0
2	Сумдын дүн	3590	3171	0	20	202	197	0
3	Агентлагийн дүн	5665	3635	0	18	1936	66	10
ДҮН		9807	7061	28	38	2407	263	10

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /%-аар/

Хүснэгт 3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Дархан-Уул аймаг	<p>Нийт 9807 өргөдлөөс</p> <p>1. Хүсэлт 9322 95.00%</p> <p>2. Санал 104 1.12%</p> <p>3. Гомдол 381 4.53%</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн байгууллагаас үзүүлдэг төрөлжсөн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл, гомдол 4015 /41.00%/ - Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 1522 /16.00%/ - Байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт 927 /9.00%/ - Газар хүссэн 757 /8.00%/ - Бусад 2586 /26.00%/ <ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг дарга С.Насанбат нь 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Залуучууд театрын их танхимд иргэд, хөдөлмөрчидтэй 3 дахь удаа томоохон хэмжээний уулзалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. • Засгийн газрын 11 11 төвөөс манай аймагт 28 иргэний санал хүсэлт гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажилласан байна. • Аймгийн Нээлттэй утас 70371212 утсаар 269 иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаа.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС